

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ 5 САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 06 дүгээр сарын 10

Мандалговь хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн Газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар зэрэг шийдвэрийн заалтуудыг хяналтад авахуулан эзэнжүүлж, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээг тасралтгүй хийж үр дүнг үнэлэх, дүгнэлт гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд оршино.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхдээ тайлан, мэдээлэл ирүүлсэн үйл явц, үр дүнг нотолж буй баримтад тулгуурлан хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-д заасан үнэлгээ өгөх аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2024 оны 5 сарын байдлаар Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан /[unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn)/-д байршуулсан 78 шийдвэр: Засгийн газрын тогтоол-57,3Г-ын хуралдааны тэмдэглэл-55, Засгийн газрын албан даалгавар-1 нийт 113 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж 84.02 хувиар үнэлэв.

Хэрэгжилтийн үнэлгээний үе шат тус бүрээр нь авч үзвэл:

- Бүрэн хэрэгжсэн 70 заалт нь нийт заалтын 61.9 хувийг
- Хэрэгжих шатанд 22 заалт нь 19 хувийг
- Хэрэгжилт хангалтгүй хэрэгжсэн 15 заалт 13 хувийг
- Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй болон аймагт хамааралгүй заалтууд 6 заалт 5 хувийг эзэлж байна.

Дундговь аймагт хэрэгжиж байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалт болон хэрэгжилтийн явцыг [Dundgov.gov.mn](http://Dundgov.gov.mn) сайт, төрийн байгууллагын цахим программ болох [erp.e-mongolia.mn](http://erp.e-mongolia.mn) программын файлын сан хэсэгт байршуулахаас гадна мэдээллийн самбарт байршуулан мэдээллээр ханган ажиллаж хэвшил болоод байна.

Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцах хуудсаар цохолт хийж, харьяа хэлтсүүд хяналтдаа авахаас гадна төрийн байгууллагын цахим системд бүх төрийн албан хаагчдад нээлттэйгээр байршуулж хяналтад авч байна.

## **ГУРАВ. ДҮГНЭЛТ**

Аймгийн хэмжээнд 5 сарын байдлаар хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 84.02 хувьтай байна. Мөн удаашралтай хэрэгжиж байгаа 15 заалтын хэрэгжилтийг авч үзвэл Санхүүжилтээс шалтгаалсан-3, Урт хугацааны туршид хэрэгжих-2, Зохион байгуулалтаас шалтгаалсан-10 заалт байна. Удаашралтай хэрэгжиж байгаа заалтуудын бодит үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр сар бүр Төрийн захиргааны удирдлагын хэлтэст зөвлөмж хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах үүднээс Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтуудыг хяналтад бүрэн авах, тайлагнахад анхаарах зарим асуудлын талаарх зөвлөмжийг сар бүр өгч ажилласнаар тодорхой үр дүн гарч байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийн явц хамгийн бага буюу 70 хувийн үзүүлэлттэй байна. Иймээс Засгийн газрын албан даалгаврын хэрэгжилтийн бодит үр дүнг нэмэгдүүлэхэд холбогдох бодлогын хэлтэс болон агентлагийн удирдлагууд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Хяналтад байгаа Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын холбогдох заалтуудаас бүрэн хэрэгжиж дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон нэг удаагийн шинжтэй 28 заалтыг түүвэрлэн хяналтаас хасуулах тэмдэглэгээг нэг бүрчлэн цахим системд орууллаа. /Хяналтаас хасуулах саналын дагуу [unelgee.gov.mn](http://unelgee.gov.mn) цахим программаас хасч өгнө үү/ жич: Хяналтаас хасуулах саналыг тусгай файлаар хүргүүлэв/

### **ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /**

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн заалтын хэрэгжилтийг нотлох баримттай тайлагнаж хэвших.

2. Хэрэгжилт нь тогтмолжсон болон тусгайлан он зааж хугацаандаа бүрэн хэрэгжээд дууссан, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан саналуудыг хяналтаас хасуулах саналаа ирүүлж хэвших.

2. Шинээр гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг сурталчлах, иргэдэд мэдээлэх ажлыг эрчимжүүлэн ажиллах.

### **ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**